



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/497

Мөрөн сум

Гэрээ хэрэгжүүлэх эрхийг сэргээх тухай.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь


1. Хогны машин худалдан авах (Тариалан сум) гэрээг цуцалсан шийдвэрийг хүчингүй болгуулах талаар “Сүүхүнгий” ХХК-ийн 2023 оны 23/1453 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлт болон тус хүсэлтийг хэлэлцсэн тухай 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор “Сүүхүнгий” ХХК-тай 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Хог зөөвөрлөх машин худалдан авах (Тариалан сум) бараа нийлүүлэх ХӨАОНӨГ/202312038-16 дугаартай 87,450,000 (Наян долоон сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийн үнэ бүхий гэрээг цуцлах тухай” аймгийн Засаг даргын 2023 оны А/454 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан Хог зөөвөрлөх машин худалдан авах (Тариалан сум) бараа нийлүүлэх ХӨАОНӨГ/202312038-16 дугаар гэрээний бараа нийлүүлэх эцсийн хугацааг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаагаар сунгаж, хэрэгжүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



d/zahiramj

6712011039